

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: САГ-2026/19/НА-СТА-ТӨА**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг:naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 51-260512 Цахим хаяг: <a href="mailto:tsogbayara@audit.gov.mn">tsogbayara@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас:51-261628 Цахим хаяг: <a href="mailto:Bujinlkhandj@audit.gov.mn">Bujinlkhandj@audit.gov.mn</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал .....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	27

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
САГ	Санхүүгийн аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ  
ХҮРЭЭЛЭН УЛСЫН ТӨСӨВТ  
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Д.ЭРДЭНЭБАЯР ТАНАА

2026.03.16 № 06/639  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5,851,716.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 3,157,500.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгож, хүлээн авсан ч хөрөнгийг бүртгэх асуудлаар захиалагч болон ашиглагч байгууллагуудтай тооцоо нийлээгүйгээс шалтгаалан техник эдийн засгийн үндэслэлийг төрийн өмчид бүртгээгүй, 2 төсөл арга, хэмжээнд нийт 636,294.2 мянган төгрөгийг үе шатаар санхүүжилтийг олгосон ч гэрээг дүгнээгүй, гэрээний хугацаа дуусгавар болсон;
2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнээс хэрэгжиж дууссан 5 төсөл, арга хэмжээний гэрээний нийт дүнгээс зарцуулагдаагүй үлдсэн 46,299.7 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг төсөвт буцаан төвлөрүүлээгүй, мөн чанарын баталгааны 16,950.0 мянган төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.2.2.6, 4.3.8.4, 4.3.9 дахь заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “ангилал”, “оршин байх”, “нийцсэн ба зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн нь өөрийн байргүй, үйл ажиллагаандаа 755.58 м.кв талбайг түрээсэлж тайлант онд ажлын байрны түрээс болон ашиглалтын зардалд нийт 739,479.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хөрөнгө оруулалтын барьцаа дансанд өмнөх онд байршуулсан 60,000,000.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс улсын төсөвт 51,451,830.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 20 төсөл, арга хэмжээнд нийт 6,883,787.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, тайлант оны эцэст 1,664,382.7 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

### **Бусад асуудал**

Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (KOICA)-аас зохион байгуулсан Монгол Улсын төрийн албан хаагчдын бүсчилсэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чадавхыг бэхжүүлэх сургалтад 8, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс (GIZ) Бүгд Найрамдах Хятад Ард Улсад зохион байгуулсан “Азийн орнуудын эмэгтэйчүүдийн чадавхыг бэхжүүлэх” семинарт 3 ажилтан хамруулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Ц.Наранчимэг* Ц.НАРАНЧИМЭГ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		120,517,561,153.00	9,068,766,990.41
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	60,000,000,000.00	1,664,382,690.59
31200	Банканд байгаа бэлэн мөнгө		60,000,000,000.00	1,664,382,690.59
31210	Төгрөг		60,000,000,000.00	1,664,382,690.59
31211	Төрийн сангийн харилцах		60,000,000,000.00	1,664,382,690.59
33	АВЛАГА	5	190,229,820.00	38,308,569.21
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		-	480,691.35
33500	Бусад авлага		190,229,820.00	37,827,877.86
33510	Байгууллагаас авах авлага		190,229,820.00	37,827,877.86
34	УРЬДЧИЛГАА		48,632,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал		48,182,000.00	-
34710	Урьдчилгаа тооцоо		450,000.00	-
34714	Томилолтын урьдчилгаа		450,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	6	278,699,333.00	38,380,804.00
35400	Хангамжийн материал		278,699,333.00	38,380,804.00
35410	Бичиг хэргийн материал		17,200,000.00	473,400.00
35440	Түлш, шатах тослох материал		7,000,000.00	-
35450	Барилгын засварын материал		250,500,000.00	-
35470	Бусад хангамжийн материал		3,999,333.00	37,907,404.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	8	60,000,000,000.00	7,327,694,926.61
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад		60,000,000,000.00	7,327,694,926.61
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		212,351,653.31	353,073,885.23
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	212,351,653.31	353,073,885.23
39200	Биет хөрөнгө		190,756,274.98	338,579,718.55
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)		134,934,800.00	453,316,028.73
39206	Хуримтлагдсан элэгдэл		(7,679,091.70)	(243,734,732.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		60,341,000.00	140,424,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл		(48,766.66)	(12,884,410.76)
39214	Бусад үндсэн хөрөнгө		3,500,000.00	3,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(291,666.66)	(2,041,666.62)
39300	Биет бус хөрөнгө		21,595,378.33	14,494,166.68
39301	Программ хангамж		17,802,764.00	17,802,764.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(1,404,885.67)	(17,802,764.00)
39303	Бусад биет бус хөрөнгө		5,940,000.00	24,340,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		(742,500.00)	(9,845,833.32)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>		<b>120,729,912,806.31</b>	<b>9,421,840,875.64</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		60,050,865,256.58	444,838,785.80
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9	60,050,865,256.58	444,838,785.80
41300	Өглөг		60,050,865,256.58	444,838,785.80
41360	Бусад өглөг		60,050,865,256.58	444,838,785.80
41361	Байгууллагад төлөх өглөг		60,050,865,256.58	443,907,665.80
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		-	931,120.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		60,679,047,549.73	8,977,002,089.84
51	Засгийн газрын хувь оролцоо		60,679,047,549.73	8,977,002,089.84
51200	Хуримтлагдсан үр дүн		60,679,047,549.73	8,977,002,089.84
51210	Өмнөх үеийн үр дүн		-	60,679,047,549.73
51220	Тайлант үеийн үр дүн		60,679,047,549.73	(51,702,045,459.89)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>		<b>120,729,912,806.31</b>	<b>9,421,840,875.64</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		62,990,976,400.00	5,510,399,678.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		3,465,000.00	5,510,399,678.08
120	Нийтлэг татварын бус орлого		3,465,000.00	26,007,478.08
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		3,465,000.00	3,850,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос		3,465,000.00	3,850,000.00
120017	Үндсэн		-	21,187,478.08
120018	Бараа		-	970,000.00
122	Тусламжийн орлого		-	5,484,392,200.00
1221	Хандив тусламж /дотоод/		-	5,484,392,200.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн		-	5,154,914,300.00
122111	Урсгал санхүүжилтийн		-	5,154,914,300.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		-	329,477,900.00
122133	ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан		-	329,474,900.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт		-	3,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		62,987,511,400.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		62,987,511,400.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		2,987,511,400.00	-
131005	Хөрөнгийн санхүүжилт		60,000,000,000.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		2,311,928,850.27	57,212,445,137.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,311,928,850.27	57,212,445,137.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,371,123,624.40	4,933,483,627.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл		617,441,750.42	2,732,442,895.76
210101	Үндсэн цалин		524,885,604.26	2,053,033,675.38
210102	Нэмэгдэл		38,841,692.16	155,605,017.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт		48,619,000.00	218,075,000.00
210104	Урамшуулал		-	305,729,202.80
210105	Гэрээт ажлын хөлс		5,095,454.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх		78,914,780.12	346,603,120.93
210201	Тэтгэврийн даатгалын зардал		53,848,320.49	236,005,192.80
210202	Тэтгэмжийн даатгалын зардал		6,335,096.24	27,855,315.95
210203	ҮОМШӨ-ний даатгалын		3,030,584.98	13,617,239.55
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал		3,030,584.98	13,594,739.55
210205	Эрүүл мэндийн даатгалын		12,670,193.43	55,530,633.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол		45,860,256.00	727,002,724.00
210301	Гэрэл, цахилгаан		1,193,264.00	131,323,900.00
210302	Түлш, халаалт		-	62,220,800.00
210303	Цэвэр, бохир ус		-	47,121,500.00
210304	Байрны түрээс		44,666,992.00	486,336,524.00
2104	Хангамж, бараа материалын зардал		172,676,850.67	90,354,349.63
210401	Бичиг хэрэг		32,803,700.00	35,233,140.00
210402	Тээвэр, шатахуун		74,194,263.00	22,735,942.14
210403	Шуудан, холбоо, интернэтийн		18,808,707.67	13,575,583.49
210404	Ном, хэвлэл		2,385,000.00	710,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал		900,000.00	270,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд		43,585,180.00	17,829,684.00
2106	Эд хогшил, урсгал засварын		2,500,000.00	240,775,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		-	8,234,600.00
210602	Тавилга		-	191,000.00
210604	Урсгал засвар		2,500,000.00	232,350,000.00
2107	Томилолт, зочны зардал		101,357,951.50	49,708,634.80
210701	Гадаад албан томилолт		47,995,251.50	17,068,734.80
210702	Дотоод албан томилолт		38,570,000.00	30,905,900.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн		14,792,700.00	1,734,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		342,205,125.00	223,487,927.30

**Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТУГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр		304,774,625.00	177,367,727.30
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		37,430,500.00	46,120,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		10,166,910.69	523,108,375.16
210901	Бараа үйлчилгээний бусад		-	319,303,729.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл		10,166,910.69	203,804,646.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		940,805,225.87	52,278,961,510.39
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		-	52,278,961,510.39
21311	Засгийн газрын дотоод		-	52,278,961,510.39
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн		-	827,131,461.79
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн		-	827,128,461.79
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн		-	3,000.00
213101	Бусад засгийн газрын дотоод		-	51,451,830,048.60
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт		940,805,225.87	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		940,805,225.87	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		60,679,047,549.73	(51,702,045,459.89)
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>		<b>60,679,047,549.73</b>	<b>(51,702,045,459.89)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	122,990,976,400.00	5,488,242,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	60,003,465,000.00	5,488,242,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	60,003,465,000.00	3,850,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,465,000.00	3,850,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,465,000.00	3,850,000.00
120009	Бусад орлого	60,000,000,000.00	-
122	Тусламжийн орлого	-	5,484,392,200.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	5,484,392,200.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	5,154,914,300.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	5,154,914,300.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	329,477,900.00
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	329,474,900.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	62,987,511,400.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	62,987,511,400.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,987,511,400.00	-
131005	Хөрөнгийн санхүүжилт	60,000,000,000.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,768,457,836.00	56,838,202,848.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,768,457,836.00	56,838,202,848.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,827,652,610.13	4,559,241,338.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	567,709,155.84	2,783,338,843.69
210101	Үндсэн цалин	476,265,739.57	2,066,123,908.51
210102	Нэмэгдэл	38,765,887.16	231,948,129.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	48,619,000.00	218,477,356.01
210104	Урамшуулал	-	266,789,450.02
210105	Гэрээт ажлын хөлс	4,058,529.11	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,914,780.12	346,603,120.93
210201	Тэтгэврийн даатгалын зардал	53,848,320.49	236,005,192.80
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	6,335,096.24	27,855,315.95
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	3,030,584.98	13,617,239.55
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	3,030,584.98	13,594,739.55
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	12,670,193.43	55,530,633.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,642,256.00	734,999,724.00
210301	Гэрэл, цахилгаан	1,402,256.00	131,323,900.00
210302	Түлш, халаалт	-	62,220,800.00

**Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТУГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210303	Цэвэр, бохир ус	-	47,121,500.00
210304	Байрны түрээс	74,240,000.00	494,333,524.00
2104	Хангамж, бараа материалын зардал	202,066,303.67	63,923,807.49
210401	Бичиг хэрэг	52,183,700.00	20,423,540.00
210402	Тээвэр, шатахуун	79,970,503.00	10,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,808,707.67	13,575,583.49
210404	Ном, хэвлэл	2,385,000.00	710,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	900,000.00	270,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	47,818,393.00	18,944,684.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	435,389,700.00	8,660,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	159,700,000.00	8,469,500.00
210602	Тавилга	5,445,000.00	191,000.00
210604	Урсгал засвар	270,244,700.00	-
2107	Томилолт, зочны зардал	108,807,951.50	49,708,634.80
210701	Гадаад албан томилолт	49,995,251.50	17,068,734.80
210702	Дотоод албан томилолт	44,020,000.00	30,905,900.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	14,792,700.00	1,734,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	359,122,463.00	242,531,807.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	303,291,963.00	196,411,607.30
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	55,830,500.00	46,120,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	329,474,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	329,474,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	940,805,225.87	52,278,961,510.39
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	52,278,961,510.39
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	52,278,961,510.39
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	827,131,461.79
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	827,128,461.79
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\	-	3,000.00
213101	Бусад засгийн газрын дотоод шилжүүлэг	-	51,451,830,048.60
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	940,805,225.87	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	940,805,225.87	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	120,222,518,564.00	(51,349,960,648.60)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	60,222,518,564.00	6,985,656,660.81
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	60,222,518,564.00	6,985,656,660.81
2200	Дотоод эх үүсвэрээр	60,222,518,564.00	6,985,656,660.81
220001	Барилга байгууламж	60,000,000,000.00	6,883,787,260.81
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	222,518,564.00	101,869,400.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(60,222,518,564.00)	(6,985,656,660.81)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	60,000,000,000.00	(58,335,617,309.41)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	60,000,000,000.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	60,000,000,000.00	1,664,382,690.59

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	60,679,047,549.73	60,679,047,549.73
10	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>60,679,047,549.73</b>	<b>60,679,047,549.73</b>
19	Тайлант үеийн үр дүн	-	-	60,679,047,549.73	60,679,047,549.73
20	<b>2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	-	-	<b>(51,702,045,459.89)</b>	<b>(51,702,045,459.89)</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>5,191,978,100.00</b>	<b>4,327,925,838.21</b>	<b>864,052,261.79</b>	<b>83.4</b>
12	Татварын бус орлого	5,191,978,100.00	4,327,925,838.21	864,052,261.79	83.4
120	Нийтлэг татварын бус орлого	-	140,000.00	(140,000.00)	
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	-	140,000.00	(140,000.00)	
122	Тусламжийн орлого	5,191,978,100.00	4,327,785,838.21	864,192,261.79	83.4
122005	Төсвөөс санхүүжих	5,191,978,100.00	4,327,785,838.21	864,192,261.79	83.4
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,191,978,100.00</b>	<b>4,327,925,838.21</b>	<b>864,052,261.79</b>	<b>83.4</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,191,978,100.00	4,327,925,838.21	864,052,261.79	83.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,191,978,100.00	4,327,925,838.21	864,052,261.79	83.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,487,471,800.00	2,783,338,843.69	704,132,956.31	79.8
210101	Үндсэн цалин	2,024,515,100.00	2,066,123,908.51	(41,608,808.51)	102.1
210102	Нэмэгдэл	1,054,185,900.00	231,948,129.15	822,237,770.85	22.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	248,770,800.00	218,477,356.01	30,293,443.99	87.8
210104	Урамшуулал	160,000,000.00	266,789,450.02	(106,789,450.02)	166.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	440,956,300.00	346,603,120.93	94,353,179.07	78.6
210201	Тэтгэврийн даатгал	299,847,300.00	236,005,192.80	63,842,107.20	78.7
210202	Тэтгэмжийн даатгал	35,280,300.00	27,855,315.95	7,424,984.05	79.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,638,200.00	13,617,239.55	4,020,960.45	77.2
210204	Ажилгүйдлийн даатгал	17,638,200.00	13,594,739.55	4,043,460.45	77.1
210205	Эрүүл мэндийн даатгал	70,552,300.00	55,530,633.08	15,021,666.92	78.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	754,242,100.00	734,999,724.00	19,242,376.00	97.4
210301	Гэрэл, цахилгаан	131,323,900.00	131,323,900.00	-	100.0
210302	Түлш, халаалт	43,374,100.00	62,220,800.00	(18,846,700.00)	143.5
210303	Цэвэр, бохир ус	47,121,500.00	47,121,500.00	-	100.0
210304	Байрны түрээс	532,422,600.00	494,333,524.00	38,089,076.00	92.8
2104	Хангамж, бараа материалын зардал	77,072,100.00	60,213,807.49	16,858,292.51	78.1
210401	Бичиг хэрэг	26,047,800.00	16,713,540.00	9,334,260.00	64.2
210402	Тээвэр, шатахуун	10,000,000.00	10,000,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,059,000.00	13,575,583.49	3,483,416.51	79.6
210404	Ном, хэвлэл	710,000.00	710,000.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	806,600.00	270,000.00	536,600.00	33.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,448,700.00	18,944,684.00	3,504,016.00	84.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	110,529,900.00	110,529,900.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	89,325,400.00	89,325,400.00	-	100.0
210602	Тавилга	21,204,500.00	21,204,500.00	-	100.0
2107	Томиллолт, зочны зардал	49,708,700.00	49,708,634.80	65.20	100.0
210701	Гадаад албан томиллолт	17,068,700.00	17,068,734.80	(34.80)	100.0
210702	Дотоод албан томиллолт	30,906,000.00	30,905,900.00	100.00	100.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,734,000.00	1,734,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	271,997,200.00	242,531,807.30	29,465,392.70	89.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	196,781,000.00	196,411,607.30	369,392.70	99.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,584,900.00	-	3,584,900.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	71,631,300.00	46,120,200.00	25,511,100.00	64.4

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	72	72	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	36	36	-	100.0
620001	Удирдах ажилтан	7	1	6	14.3
620002	Гүйцэтгэх ажилтан	29	35	(6)	120.7

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>329,477,900.00</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	329,477,900.00
122	Тусламжийн орлого	329,477,900.00
1221	Хандив тусламж /дотоод/	329,477,900.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	329,477,900.00
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	329,474,900.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,000.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>329,474,900.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	329,474,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	329,474,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	329,474,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	329,474,900.00
<b>4</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>3,000.00</b>
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(3,000.00)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(3,000.00)

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 14-ны өдрийн 33 дугаар тогтоолоор "Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн" УТҮГ нь Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд үүсгэн байгуулагдсан. Монгол Улсын Шадар сайдын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 59 тоот тушаалаар тус хүрээлэнгийн бүтэц, орон тоо батлагдсанаар үйл ажиллагаагаа эхэлсэн байна.

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ нь Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсүүдийн хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, оролцогч байгууллага, салбарын үйл ажиллагааны уялдааг хангах, тэдгээрт мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант оны онцлог үйл явдлууд:

- ✚ Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хорооны хуралдааныг 2025 оны 2 дугаар сарын 3-ний өдөр зохион байгуулсан;
- ✚ Хангайн бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдааныг Архангай аймагт 2025 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр, Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдааныг Булган аймагт 2025 оны 4 дүгээр сарын 28-ний өдөр, Говийн бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдааныг Дорноговь аймагт 2025 оны 5 дугаар сарын 12-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан;
- ✚ Уул уурхайн 7 хоног арга хэмжээний хүрээнд "Бүсийн хөгжил-уул уурхай-орон нутаг" сэдэвт салбар хуралдаан, 21 аймгийн уул уурхайн компани, хоршоодын үзэсгэлэн, Багануур, Багахангай, Налайх дүүргийн хөгжлийн чуулган, Төвийн болон Зүүн бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хэлэлцүүлгийг 2025 оны 9 дүгээр сарын 11, 12-нд өдрүүдэд тус тус зохион байгуулсан;

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ нь Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажилладаг.

Тайлант хугацаанд байгууллагын болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд голлон мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дахь заалт;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 15 дугаар зүйлийн 15.1.8, 15.2.7 дахь заалт;
- Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн "Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 52 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам";
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн "Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 04 дүгээр албан даалгавар;
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" 05 дугаар албан даалгавар гаргасан.

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант хугацаанд Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын хууль тогтоомж, тушаал шийдвэр, албан даалгаврын биелэлт, хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт, ажилтны цагийн бүртгэл, сургалт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, архив, албан хэргийн хөтлөлт, хөрөнгийн тооллого, худалдан авах ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлж санал, дүгнэлт гаргаж, сайжруулах үүрэг чиглэл өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар судалж, танилцсан бөгөөд дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын гүйцэтгэх захирлын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/114 дүгээр тушаалаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж шинэчлэн баталсан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Монгол Улсын Сангийн Сайдын тушаалаар баталсан журам, заавар, аргачлалын шаардлагад нийцсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 111,308,071.9 мянган төгрөгөөр буюу 92.2 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /буурсан - , нэмэгдсэн +/
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	60,000,000.0	1,664,382.7	(58,335,617.3)
Авлага	190,229.8	38,308.6	(151,921.2)
Урьдчилгаа	48,632.0	-	(48,632.0)
Бараа материал	278,699.3	38,380.8	(240,318.5)
Бусад эргэлтийн хөрөнгө	60,000,000.0	7,327,694.9	(52,672,305.1)
Үндсэн хөрөнгө	212,351.7	353,073.9	140,722.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>120,729,912.8</b>	<b>9,421,840.9</b>	<b>(111,308,071.9)</b>
Өглөг	60,050,865.3	444,838.8	(59,606,026.5)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	60,679,047.5	8,977,002.1	(51,702,045.4)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>120,729,912.8</b>	<b>9,421,840.9</b>	<b>(111,308,071.9)</b>

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өглөг, засгийн газрын хувь оролцоо данснууд байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,664,382.7 мянган төгрөг болж, өмнөх оны үлдэгдлээс 58,335,617.3 мянган төгрөгөөр буурсан нь барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан мөнгөн хөрөнгөнөөс улсын төсөвт 51,451,830.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд 6,883,787.3 мянган төгрөгийг санхүүжүүлсэнтэй холбоотой;
- Авлагын дансны үлдэгдэл 38,308.6 мянган төгрөг болж, 151,921.2 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагаас авах авлагыг барагдуулсантай холбоотой. Тайлант хугацаанд байр түрээсийн 37,779.0 мянган төгрөгийн барьцаа байршуулсныг авлагаар тайлагнаж, ажиллагсадтай холбоотой 480.7 мянган төгрөгийн, шатахууны 48.9 мянган төгрөгийн авлага нэмэгдсэн;
- Урьдчилгаа дансны үлдэгдэлгүй болж, 48,632.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд байр түрээсийн зардалд урьдчилж төлсөн 29,782.0 мянган төгрөгийн тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч, 18,400.0 мянган төгрөгийн үнэ бүхий байгууллагын вэф сайтыг хүлээж авч биет бус хөрөнгөд бүртгэсэн, ажилчид олгосон томилолтын урьдчилгаа 450.0 мянган төгрөгийг цалингаас суутгаж тооцсонтой холбоотой;
- Бараа материалын дансны үлдэгдэл 38,380.8 мянган төгрөг болж, 240,318.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 151,670.7 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан, байгууллагаас авах өмнөх оны авлагын үлдэгдлээс 17,950.0 мянган төгрөгийн материал хүлээн авч, Эдийн засаг, хөгжлийн яамнаас 970.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, үйл ажиллагаандаа 410,909.2 мянган төгрөгийн материалыг зарцуулсантай холбоотой;
- Бусад эргэлтийн хөрөнгийн дансны үлдэгдэл 7,327,694.9 мянган төгрөг болж, 52,672,305.1 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын дансны үлдэгдлийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэнтэй холбогдуулан 60,000,000.0 мянган төгрөгийг бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэснийг тайлант хугацаанд залруулан хөрөнгө оруулалтын цэвэр гүйцэтгэлээр тайлагнасанатай холбоотой;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 353,073.9 мянган төгрөг болж, 140,722.2 мянган төгрөгөөр өссөн нь:
  - ✓ Тайлант онд төсвийн хөрөнгөөр 101,869.4 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн;
  - ✓ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 02/44 албан бичгээр Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод үр ашигтай байдал төслөөс 5,148.9 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлж авсан;
  - ✓ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 749 дүгээр тогтоолоор Эдийн засаг, хөгжлийн яамнаас 16,038.5 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй үндсэн хөрөнгийг шилжүүлэн авсан;
  - ✓ Өмнөх оны байгууллагаас авах авлагаас 164,945.0 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж хүлээн авсан;
  - ✓ Барилгын засварын материалаас 18,150.0 мянган төгрөгийн материалыг зарлагадаж байгууллагатай 19,975.0 мянган төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулснаар 38,125.0 мянган төгрөгийн тавилгыг хийлгэсэн;
  - ✓ Урьдчилж гарсан зардлаас 18,400.0 мянган төгрөгийн вэф сайтыг орлого авсан;
  - ✓ Тайлант хугацаанд 203,804.6 мянган төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой;
- Өглөг дансны үлдэгдэл 444,838.8 мянган төгрөг болж, 59,606,026.5 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансны үлдэгдэл 60,000,000.0 мянган төгрөгийн өглөг тайлагнасныг залруулж, хувь хүний орлогын албан татварын 50,865.2 мянган төгрөгийн өглөгийг барагдуулж, тайлант хугацаанд захиалагчийн хяналтын зардлын 149,705.9 мянган төгрөгийн, чанарын баталгааны 294,201.7 мянган төгрөгийн, хувь хүнд өгөх 931.1 мянган төгрөгийн өглөг нэмэгдсэнтэй холбоотой;
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 8,977,002.1 мянган төгрөг болж, тайлант оны санхүүгийн үр дүнгийн өөрчлөлтөөр 51,702,045.4 мянган төгрөгөөр буурсан.

Программ хангамжийн талаарх судалгаа авахад 5,940.0 мянган төгрөгийн үнэ бүхий Юникус санхүүгийн программыг байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байна. Харин 17,802.7 мянган төгрөгийн үнэ бүхий Microsoft 365-д төрийн байгууллагын албан бичиг боловсруулах, дотоод харилцаа холбоог сайжруулах, мэдээллийг аюулгүй хадгалах, байгууллагын ажлын уялдаа холбоо болон хяналтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэгдсэн программын жилийн эрхийг программ хангамжид тайлагнасан нь бүртгэлийн хувьд алдаатай байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын 2025 оны төсвийн төсөлд урсгал үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 17,207,463.0 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн урсгал үйл ажиллагааны зардлыг төсвийн саналаас 10,976,603.4 мянган төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс 6,230,859.6 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр баталжээ. Энэ нь 2025 онд Бүсчилсэн хөгжлийн цахим мэдээллийн системийг шинэчлэх, орон зайн төлөвлөлт, хяналт, удирдлагын систем шинээр бий болгох, бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах арга, зүй, төсөл, орон нутгийн хөгжлийн 21 төвийн хөдөө, аж ахуйн үйлдвэрлэл, технологийн парк шинэчлэх зэрэг ажилд төсөв боловсруулж хүргүүлсэн нь дэмжигдээгүйтэй холбоотой байна.

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2, 42 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын 2025 оны батлагдсан төсвөөс 1 удаагийн төсвийн өөрчлөлт хийж байгууллагад шаардлагатай төсвийг хуваарилж, мөн Монгол Улсын 2025 оны төсөвт 1 удаа тодотгол хийгдсэн байна.

Тайлант оны 1 дүгээр сард томилолтын зардлыг 90,000.0 мянган төгрөгөөр, тавилга эд хогшлын зардлыг 50,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, байрны түрээсийн зардлыг 90,000.0 мянган төгрөгөөр, багаж, техник хэрэгслийг 50,000.0 мянган төгрөгөөр бууруулж төсвийн зохицуулалт хийжээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголыг 07 дугаар сард хийхдээ батлагдсан төсвийг 8.3 хувь буюу 1,038,881.5 мянган төгрөгөөр бууруулж 5,191,978.1 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,191,978.1 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 5,154,914.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 37,063.8 мянган төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна. Тайлант онд 140.0 мянган төгрөгийн туслах үйл ажиллагааны орлого бүрдүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,327,925.8 мянган төгрөг буюу 83.4 хувь байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 863,682.9 мянган төгрөгөөр, Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зардлыг 369.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулж, зарцуулаагүй 827,128.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>70107</b>	<b>Бүсчилсэн хөгжлийн бодлого, удирдлага</b>	<b>5,191,978.1</b>	<b>4,327,925.8</b>	<b>864,052.3</b>	<b>83.4</b>
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	4,995,197.1	4,131,514.2	863,682.9	82.7
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	196,781.0	196,411.6	369.4	99.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

- ✚ Байгууллагын орон тооны цомхотгол: “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгаж оновчтой болгох, төрийн үйлчилгээг цахим болгох ажлыг эрчимжүүлэх, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-нд туссан багш, эмч нараас бусад төрийн албан хаагчийг орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээг 2025 онд эхлүүлсэн. Тус байгууллагын батлагдсан орон тоо 40 байсныг 4 орон тоогоор бууруулан 36 орон тоотой ажилласан байна.
- ✚ Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын гүйцэтгэх захирлын 2024 оны Б/21 дүгээр тушаалаар албан хаагчдын ажлын нэг өдрийн хоолны мөнгийг 22.0 мянган төгрөгөөр, унааны төлбөрийг 3.0 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд унаа хоолны хөнгөлөлтийн зардалд 248,770.8 мянган төгрөгийг төлөвлөснөөс тайлант хугацаанд 218,477.3 мянган төгрөгийг зарцуулж, 30,293.4 мянган төгрөгийг хэмнэжээ.
- ✚ Гадаад томилолтын зардалд 17,068.7 мянган төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 17,067.7 мянган төгрөгийг тайлагнасан.
- ✚ Чанарын менежментийн тогтолцоо, шаардлага /MNS ISO:9001 2016/ стандартын сургаалтанд ажилчдыг хамруулж 4,924.5 мянган төгрөгийг зарцуулсан;
- ✚ Бүсчилсэн хөгжлийг үзэл баримтлалыг олон нийтэд түгээх, танилцуулах чиглэлээр тайлант хугацаанд 89,346.0 мянган төгрөгийн гэрээ байгуулснаас 46,496.0 мянган төгрөгийг санхүүжүүлсэн;
- ✚ Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-т төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал гараагүй болно.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 50 дугаар тогтоолын дагуу бүсийн өргөтгөсөн хуралдааныг тайлант онд бүс тус бүрд зохион байгуулахад шаардагдах төсвийн нийт 329,477.9 мянган төгрөгийн орлого төвлөрч, гүйцэтгэлээр 329,474.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 3.0 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

**Худалдан авах ажиллагаа:** Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын 2025 онд урсгал төсвийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 4 багц бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад нийт 176,000.0 мянган төгрөгийн төсвийг баталсан.

Тайлант онд худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдлөг болгон зохион байгуулсан, 58,100.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй компьютер тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс ерөнхий гэрээ байгуулан 54,120.0 мянган төгрөгөөр худалдан авсан байна.

Бүсчилсэн хөгжлийн бодлого, үйл ажиллагааны талаар иргэд, олон нийтийн мэдээлэл, мэдлэг, байр суурийн талаарх судалгааны 100,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий ажил, Мэргэжлийн камер авах 17,900.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан боловч оролцогч байхгүйн улмаас хэрэгжээгүй байна.

**Хөрөнгө оруулалт:** Засгийн газрын 2025 оны 97 дугаар тогтоолоор барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хөрөнгийн худалдан авах ажиллагааны ажлын даалгаврыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлснээр тайлант онд 6 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж 2024 онд байгуулсан 15, нийт 12,485,725.2 мянган төгрөгийн өртөг бүхий 21 төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллажээ.

Тайлант хугацаанд 20 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчид гэрээнд заасан үе шатны нийт 6,883,787.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон. Оны эцэст нийт 21 төсөл, арга хэмжээнээс бүрэн дууссан 18 төсөл, арга хэмжээг бүрэн хүлээн авч, 2 төсөл, арга хэмжээний гэрээний хугацаа дууссан боловч гэрээг дүгнээгүй, 1,950,000.0 төсөвт өртөг бүхий Багануур, Багахангай, Налайх хотуудыг хөгжүүлэх ТЭЗҮ, үзэл баримтлал /концепц/, ерөнхий төлөвлөгөө /Багануур, Багахангай, Налайх дүүрэг/-ний гүйцэтгэгчтэй хийсэн гэрээг цуцалсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын 2025 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой тооцоо нийлсэн акт, хөрөнгийн бүртгэл, хөрөнгө оруулалтын санхүүжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитор С.Болортуяа нар гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 26/34 дугаар албан бичгээр ирүүлсэн.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнийг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн болох 2,311,928.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 23,119.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн төслийн саналаар хүргүүлсэн зарим зардлыг татаж баталсан, аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 41 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэхэд зөрчил, дутагдал илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 5,325,744.9 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснээс, 5,325,744.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг хүргүүлсэн.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Онцгой байдлын ерөнхий газар нь Шилэн дансны цахим системд байршуулбал зохих зарим мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Тухайлбал:

- ✓ Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг- 6 удаа;
- ✓ Дараа жилийн зорилтот түвшин-1удаа;
- ✓ Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт-3 удаа;
- ✓ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 14 мэдээллийн 4,053,663.4 мянган төгрөг;
- ✓ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн 30 гүйлгээний 1,272,081.5 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:”, 6.4.3-т “тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;”, 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;” гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан цаглаварт хугацаанд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, давтан гаргасан, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны тухай хуулийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчил илрээгүй болно.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын 2025 оны III улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 2,430,157.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн 2,378,322.6 мянган төгрөгийн 8 алдааг залруулан, 51,835.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах талаар 7 зөвлөмж хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэж, хэрэгжилтийг үнэлэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оноос дамжин хэрэгжүүлсэн 12, 2025 онд шинээр гэрээ байгуулсан 6, нийт 18 төсөл, арга, хэмжээний гэрээний хугацаа 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон байсныг 2025 оны 12 дугаар сарын 30-ний өдрөөр сунгаж, 18 төсөл, арга хэмжээг бүрэн хүлээн авсан.

- Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж батлуулсан.
- Албан хаагчдын 1,728.2 мянган төгрөгийн цалин хөлсийг татварын тайланд, 1,600.0 мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалын тайланд нөхөн тайлагнажээ.
- Тайлант хугацаанд бичиг хэргийн 12,165.0 мянган төгрөг, аж ахуйн материал 9,536.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 5,656.6 мянган төгрөг, бэлэн бүтээгдэхүүн 1,353.0 мянган төгрөг нийт 28,710.7 мянган төгрөгийн материалыг бараа материалын дансанд орлого, зарлагаар тусгаагүй шууд зарлагадсан зөрчлийг арилгасан.
- Тайлант хугацаанд худалдан авсан 12,946.3 мянган төгрөгийн бараа материалыг эд хариуцагчийн тайланд орлого, зарлагаар тайлагнасан
- “Баттрейд” ХХК-тай байр түрээсийн тооцоо нийлж, өр, авлагын үлдэгдэлгүй болсон байна.

Завсрын аудитаар илэрсэн зөрчлийг арилгаагүй Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 асуудалд санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага хүргүүлсэн.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 60,454,762.6 мянган төгрөгийн 6 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлж, 227,973,888.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснөөс 222,648,144.1 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг биелүүлж, аудитын шийдвэрийн хэрэгжилтийн дунджаар 98.2 хувьтай байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	6	60,454,762.6	6	60,454,762.6	100.0
Зөвлөмж	3	227,973,888.9	2	222,648,144.1	97.7
<b>Нийт дүн</b>	<b>9</b>	<b>288,428,651.5</b>	<b>8</b>	<b>283,102,906.7</b>	<b>98.2</b>

Өмнөх аудитаар өгсөн шийдвэрээс хэрэгжээгүй 5,325,744.8 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хувьд Шилэн дансны тухай хуулийн дагуу цахим хуудсанд мэдээллийг хугацаа хоцруулан мэдээлсэн зөрчил арилаагүй, тайланд онд давтан гаргасан тул дараагийн шатны шийдвэр албан шаардлага хүргүүлсэн.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эх үүсвэрээр хэрэгжиж дуусаад захиалагч болон ашиглагч байгууллагад бүрэн хүлээлгэн өгсөн хөрөнгийг тооцоо нийлж төрийн өмчид бүртгүүлсэн эсэх, программ ашиглах жилийн эрхийг программ хангамжид тайлагнасан асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн эсэхэд горим сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,215,927.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ. Үүнд:

### Залруулсан алдаа:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсвийг 252,702.3 мянган төгрөгөөр, зардлын гүйцэтгэлийг 3,710.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй илэрхийлсэн;
- Санхүүгийн байдлын тайланд бусад эргэлтийн бусад хөрөнгийг 3,458,507.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эх үүсвэрээр хэрэгжсэн 18 төсөл, арга хэмжээний 149,705.9 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын, 294,201.7 мянган төгрөгийн чанарын баталгааны өглөгийг тайлагнаагүй;
- Бараа материалын тодруулгын дансны ангиллын орлого, зардлыг 61,380.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Эдийн засгийн хөгжлийн яамнаас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 970.0 мянган төгрөгийн, урьдчилж төлсөн зардлаас бэлтгэсэн 17,950.0 мянган төгрөгийн, нийт 18,920.0 мянган төгрөгийн материалыг бараа материалын тодруулгад төсвийн хөрөнгөөр худалдаж авснаар тайлагнасан;
- Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй гарсан зардлыг 2,976,800.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.

Эдгээр алдаанууд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулгын 1.27, УСНББОУС-17 Үндсэн хөрөнгийн 17.42 дахь параграф болон санхүүгийн аудитын "Оршин байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 5,851,716.6 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд, 70,364.2 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 636,294.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлагыг хүргүүлж, 5,145,058.4 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 5,851,716.6 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5,828,597.3 мянган төгрөгөөр давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд нэр бүхий 8 албан хаагчид 7,114.5 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчид илүү олгосон 7,114.5 мянган төгрөгийн цалинг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр бүрэн хэрэгжиж дууссан 5 төсөл, арга хэмжээний гэрээний нийт дүнгээс зарцуулагдаагүй үлдсэн 46,299.7 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг төсөвт буцаан төвлөрүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно", 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.3.8.4-д "энэ журмын 4.3.8.1-д заасан зардлыг төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх, төслийг ашиглалтад бүрэн оруулахтай холбоотой үйл ажиллагаанд захиалагчийн эрх, үүргээр зарцуулах бөгөөд өөр зориулалтаар зарцуулахгүй байх", 4.3.9-д "Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь хэрэгжиж дууссан, ашиглалтад орсонтой холбогдуулан энэ журмын 4.3.8-д заасан зардлаас зарцуулагдаагүй үлдсэн зардлыг төсөвт буцаан төвлөрүүлнэ;" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хэрэгжиж дууссан 5 төсөл, арга хэмжээний гэрээний нийт дүнгээс зарцуулагдаагүй үлдсэн захиалагчийн хяналтын зардлын 46,299.7 мянган төгрөгийг улсын орлогын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хэрэгжсэн Стандарт, хэмжил зүйн газрын өргөтгөлийн барилгын зураг, төслийг хэрэгжүүлэгч "Смарт прожект" ХХК-тай байгуулсан гэрээнд гэрээт ажлын баталгаат хугацааг 1 жил байхаар заасан боловч чанарын баталгааны 16,950.0 мянган төгрөгийг барьцаа дансанд байршуулаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 4.2.2.5-т "төсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх", 4.2.2.6-д "чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг гүйцэтгэл тус бүрээс, эсхүл эцсийн буюу бүрэн санхүүжилтээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43.6-д заасны дагуу суутган барьцаа хөрөнгийн дансанд байршуулах асуудлыг тухайн төсөл, арга хэмжээний гэрээний тусгай нөхцөлд тусгасан байх;" гэж заасныг тус тус зөрчсөн байна..

Шийдвэрлэсэн нь: Гэрээнд заасан чанарын баталгааны 16,950.0 мянган төгрөгийг "Смарт прожект" ХХК-аар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

5.2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хэрэгжүүлж буй 413,891.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй Орон нутгийн хөгжлийн төвд байгалийн нөхцөл нөөцөд тулгуурлан үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборын ТЭЗҮ /Хөвсгөл аймаг/ хийлгэхээр "Эс Ай Си Эй" ХХК-тай 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр гэрээ байгуулж эхний үе шатны 30 хувийн санхүүжилт болох 124,167.6 мянган төгрөгийг 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр шилжүүлсэн боловч гэрээг дүгнээгүй, гэрээний хугацаа 2025 оны 12 дугаар сарын 30-ний өдрөөр дуусгавар болсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч,

худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын гүйцэтгэх захирал, Хүнс, Хөдөө, Аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн дарга, "Эс Ай Си Эй" ХХК-ийн гүйцэтгэх захирал нарын хооронд 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан "Орон нутгийн хөгжлийн төвд хөдөө аж ахуйн нөөцөд тулгуурлан үйлдвэрлэл, үйлчилгээ, бирж, тээвэр логистикийн цогцолбор ТЭЗҮ" боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээний 1.2-т "Гэрээний хугацаа 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн хооронд байна", 8.2-т "Захиалагч дээрх үндэслэлээс гадна хэдий ч гэрээг цуцалж болно", 9.5-д "Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0.05 хувиар заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна", 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн гэрээний нэмэлт өөрчлөлтийн 2.1-т Гэрээний 1.2 дахь хэсэгт... гэснийг "Гэрээний хугацаа нь 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хооронд байна" гэж өөрчлөх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан гэрээний хугацаа дууссан байхад хэрэгжилтийг бүрэн хангуулаагүй зөрчлийг арилгаж, гэрээг дүгнэх талаар албан шаардлага хүргүүлэв.

5.2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хэрэгжүүлж буй Мэдээллийн технологийн төрөлжсөн төвийг байгуулах ТЭЗҮ, зураг төсөл /6 бүс тус бүрд/ боловсруулахаар "Өрнөлпроект" ХХК-тай 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 746,540.3 мянган төгрөгийн гэрээ байгуулж эхний болон дундын үе шатны 70 хувийн санхүүжилт болох 512,126.6 мянган төгрөгийг санхүүжүүлсэн боловч гэрээг дүгнээгүй, гэрээний хугацаа 2025 оны 12 дугаар сарын 30-ний өдрөөр дуусгавар болсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын гүйцэтгэх захирал, Цахим хөгжил, Инновац, Харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, "Өрнөлпроект" ХХК-ийн захирал нарын хооронд 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан "Мэдээллийн технологийн төрөлжсөн төвийг байгуулах ТЭЗҮ, зураг төсөл /6 бүс тус бүрд/" боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээний 1.2-т "Гэрээний хугацаа 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн хооронд байна", 8.2-т "Захиалагч дээрх үндэслэлээс гадна хэдий ч гэрээг цуцалж болно", 9.5-д "Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0.05 хувиар заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна", 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн гэрээний нэмэлт өөрчлөлтийн 2.1-т "Гэрээний 1.2 дахь хэсэгт... гэснийг "Гэрээний хугацаа нь 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хооронд байна" гэж өөрчлөх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан гэрээний хугацаа дууссан байхад хэрэгжилтийг бүрэн хангуулаагүй зөрчлийг арилгаж, гэрээг дүгнэх талаар албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:

**Илрүүлэлт 1:** Тайлант хугацаанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 3,157,500.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгож, хүлээн авсан боловч хөрөнгийг бүртгэх асуудлаар захиалагч болон ашиглагч байгууллагатай тооцоо нийлээгүйн улмаас ТЭЗҮ-г төрийн өмчид бүртгээгүй, тус газрын эргэлтийн бус хөрөнгөнд бүртгэлтэй байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 5.5.1-д "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон орон нутгийн өмч байх буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авсан, тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон зураг төсөл, ТЭЗҮ-г захиалагч хүлээн авсны дараа төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлнэ;"; 5.5.2-д "Энэ журмын 5.5.1-д заасан хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлэх чиг үүргийг захиалагчийн өмчийн асуудал хариуцсан нэгж (ажилтан) хэрэгжүүлэх бөгөөд өмчид бүртгүүлэхийг тодорхойлох урьдчилсан маягыг бөглөн цахим системээр гүйцэтгэлийн санхүүжилтийн хүсэлтэд хамт ирүүлж, цахим системийн өмчийн санд мэдээллийн санг бүрдүүлнэ;"; 5.5.3-д "Өмчийн эцсийн өмчлөгчийг тодорхойлсон шийдвэрийн дагуу төрийн өмчийн бүртгэлийн нэгдсэн системд өмчийн бүртгэл хийгдсэнээр цахим систем дэх урьдчилсан бүртгэлийн мэдээлэл баталгаажиж өмчийн мэдээллийн санд бүртгэгдэнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр бүрэн хэрэгжиж, хүлээн авсан хөрөнгийг захиалагч болон ашиглагч байгууллагатай тооцоо нийлж төрийн өмчид бүртгүүлж байх.

2. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эх үүсвэртэй холбоотой асуудал:

**Илрүүлэлт 2:** Тайлант оны эцэст хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчид өгөх хүлээгдэж байгаа санхүүжилтийн бодит үлдэгдлийг тооцолгүй Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын барьцаа хөрөнгийн дансны үлдэгдлээс Сангийн яамны хөрөнгө оруулалтын дансанд мөнгө төвлөрүүлснээр гэрээт хугацаанд гүйцэтгэгчээс хүлээлгэн өгсөн 18, он дамжин хэрэгжиж байгаа 2 төсөл, арга хэмжээний 1,987,558.2 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр дутагдсан, энэ талаар Сангийн яамтай тооцоо нийлж эцэслээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;"; 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Улсын төсвийн хөрөнгө, оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн дутагдсан 1,987,558.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг Сангийн яамтай тооцоо нийлж шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсвийг 252,702.3 мянган төгрөгөөр, зардлын гүйцэтгэлийг 3,710.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй илэрхийлсэн.	1	256,412.3	-	-	1	256,412.3	1	256,412.3	-	-	-	-
Санхүүгийн байдлын тайланд бусад эргэлтийн бусад хөрөнгийг 3,458,507.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.	1	3,458,507.7	-	-	1	3,458,507.7	1	3,458,507.7	-	-	-	-
Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эх үүсвэрээр хэрэгжсэн 18 төсөл, арга хэмжээний 149,705.9 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын, 294,201.7 мянган төгрөгийн чанарын баталгааны өглөгийг тайлагнаагүй.	1	443,907.6	1	443,907.6	-	-	1	443,907.6	-	-	-	-
Бараа материалын тодруулгын дансны ангиллын орлого, зардлыг зөрүүтэй илэрхийлсэн.	1	61,380.0	-	-	1	61,380.0	1	61,380.0	-	-	-	-
Эдийн засгийн хөгжлийн яамнаас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 970.0 мянган төгрөгийн, урьдчилж төлсөн зардлаас бэлтгэсэн 17,950.0 мянган төгрөгийн, нийт 18,920.0 мянган төгрөгийн материалыг бараа материалын тодруулгад төсвийн хөрөнгөөр худалдаж авснаар тайлагнасан	1	18,920.0	-	-	1	18,920.0	1	18,920.0	-	-	-	-
Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй гарсан зардлыг зөрүүтэй илэрхийлсэн.	1	2,976,800.0	-	-	1	2,976,800.0	1	2,976,800.0	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>7,215,927.6</b>	<b>1</b>	<b>443,907.6</b>	<b>5</b>	<b>6,772,020.0</b>	<b>6</b>	<b>7,215,927.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН УТУГ-ЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Тайлант онд зарим албан хаагчид цалинг илүү тооцож олгосон.	1	7,114.5	1	7,114.5	-	-	-	-	-	-
Улсын төсвийн санхүүжилтээр бүрэн хэрэгжиж дууссан 5 төсөл, арга хэмжээний гэрээний нийт дүнгээс зарцуулагдаагүй үлдсэн 46,299.7 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг төсөвт буцаан төвлөрүүлээгүй.	1	46,299.7	1	46,299.7	-	-	-	-	-	-
Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хэрэгжсэн барилгын зураг, төслийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээнд гэрээт ажлын баталгаат хугацааг 1 жил байхаар заасан боловч чанарын баталгааны 16,950.0 мянган төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүй.	1	16,950.0	1	16,950.0	-	-	-	-	-	-
Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хэрэгжүүлж буй 413,891.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй Орон нутгийн хөгжлийн төвд байгалийн нөхцөл нөөцөд тулгуурлан үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборын ТЭЗҮ /Хөвсгөл аймаг/ хийлгэхээр "Эс Ай Си Эй" ХХК-тай 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр гэрээ байгуулж эхний үе шатны 30 хувийн санхүүжилт болох 124,167.6 мянган төгрөгийг 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр шилжүүлсэн боловч гэрээг дүгнээгүй, гэрээний хугацаа 2025 оны 12 дугаар сарын 30-ний өдрөөр дуусгавар болсон.	1	124,167.6	-	-	1	124,167.6	-	-	-	-
Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хэрэгжүүлж буй Мэдээллийн технологийн төрөлжсөн төвийг байгуулах ТЭЗҮ, зураг төсөл /6 бүс тус бүрд/ боловсруулахаар "Өрнөлпроект" ХХК-тай 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 746,540.3 мянган төгрөгийн гэрээ байгуулж эхний болон дундын үе шатны 70 хувийн санхүүжилт болох 512,126.6 мянган төгрөгийг санхүүжүүлсэн боловч гэрээг дүгнээгүй, гэрээний хугацаа 2025 оны 12 дугаар сарын 30-ний өдрөөр дуусгавар болсон.	1	512,126.6	-	-	1	512,126.6	-	-	-	-
Тайлант хугацаанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 3,157,500.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 6	1	3,157,500.0	-	-	-	-	1	3,157,500.0	-	-

**БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН УТУГ-ЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгож, хүлээн авсан боловч хөрөнгийг бүртгэх асуудлаар захиалагч болон ашиглагч байгууллагатай тооцоо нийлээгүйгээс ТЭЗҮ-г төрийн өмчид бүртгээгүй, тус газрын эргэлтийн бус хөрөнгөнд бүртгэлтэй.										
Тайлант оны эцэст хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчид өгөх хүлээгдэж байгаа санхүүжилтийн бодит үлдэгдлийг тооцолгүй тус газрын барьцаа хөрөнгийн дансны үлдэгдлээс Сангийн яамны хөрөнгө оруулалтын дансанд төвлөрүүлснээр гэрээт хугацаанд гүйцэтгэгчээс хүлээлгэн өгсөн 18, он дамжин хэрэгжиж байгаа 2 төсөл, арга хэмжээний нийт 1,987,558.2 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр дутагдсан, Сангийн яамтай тооцоо нийлж баталгаажуулаагүй.	1	1,987,558.2	-	-	-	-	1	1,987,558.2	-	-
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>5,851,716.6</b>	<b>3</b>	<b>70,364.2</b>	<b>2</b>	<b>636,294.2</b>	<b>2</b>	<b>5,145,058.2</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
<i>Шилэн дансны тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>									
"Шилэн дансны цахим системд байршуулбал зохих мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Тухайлбал: ✓ Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг- 6 удаа; ✓ Дараа жилийн зорилтот түвшин-1удаа; ✓ Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт-3 удаа; ✓ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 14 мэдээллийн 4,053,663.4 мянган төгрөг; ✓ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн 30 гүйлгээний 1,272,081.5 мянган төгрөгийн мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн.	1	5,325,744.9	-	-	1	5,325,744.9	-	-	
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>5,325,744.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>5,325,744.9</b>	<b>-</b>	<b>-</b>	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 137/A0160259

Улаанбаатар хот

САГ - 2026/19/НА - СТА - ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нэр бүхий 8 албан хаагчид 7,114,503.00 (долоон сая нэг зуун арван дөрвөн мянга таван зуун гурван) төгрөгийн цалинг илүү тооцож олгосон.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Хавсралтад дурдсан нэр бүхий 8 албан хаагчид илүү олгосон нийт 7,114,503.00 (долоон сая нэг зуун арван дөрвөн мянга таван зуун гурван) төгрөгийг тооцооллын алдаа гаргасан нягтлан бодогч Б.Цолмон, ахлах нягтлан бодогч Ч.Аюурзана нараар нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын гүйцэтгэх захирал (Д.Эрдэнэбаяр)-т хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Ж.БУЖИНХАНД



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 132/АД160259

Улаанбаатар хот

САГ - 2026/19/НА - СТА - ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр бүрэн хэрэгжиж дууссан хавсралтад заасан 5 төсөл, арга хэмжээний гэрээний нийт дүнгээс зарцуулагдаагүй үлдсэн 46,299,720.00 (дөчин зургаан сая хоёр зуун ерэн есөн мянга долоон зуун хорин) төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг төсөвт буцаан төвлөрүүлээгүй.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.3.8.4-д "энэ журмын 4.3.8.1-д заасан зардлыг төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх, төслийг ашиглалтад бүрэн оруулахтай холбоотой үйл ажиллагаанд захиалагчийн эрх, үүргээр зарцуулах бөгөөд өөр зориулалтаар зарцуулахгүй байх", 4.3.9-д "Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь хэрэгжиж дууссан, ашиглалтад орсонтой холбогдуулан энэ журмын 4.3.8-д заасан зардлаас зарцуулагдаагүй үлдсэн зардлыг төсөвт буцаан төвлөрүүлнэ;" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.4-т "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Хэрэгжиж дууссан хавсралтад заасан 5 төсөл, арга хэмжээний гэрээний нийт дүнгээс зарцуулагдаагүй үлдсэн захиалагчийн хяналтын зардлын 46,299,720.00 (дөчин зургаан сая хоёр зуун ерэн есөн мянга долоон зуун хорин) төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын гүйцэтгэх захирал (Д.Эрдэнэбаяр), ахлах нягтлан бодогч (Ч.Аюурзана) нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБЯАР  
Ж.БҮЖИНХАНД

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264 30

Z: Акт-2026/0316 САГ-А.Доex

1526200116



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 133/АД160259

Улаанбаатар хот

САГ - 2026/19/НА - СТА - ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хэрэгжсэн Стандарт, хэмжил зүйн газрын өргөтгөлийн барилгын зураг, төслийг хэрэгжүүлэгч "Смарт прожект" ХХК-тай байгуулсан гэрээнд гэрээт ажлын баталгаат хугацааг 1 жил байхаар заасан боловч чанарын баталгааны 16,950,000.00 (арван зургаан сая есөн зуун тавин мянган) төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 4.2.2.5-т "төсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх", 4.2.2.6-д "чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг гүйцэтгэл тус бүрээс, эсхүл эцсийн буюу бүрэн санхүүжилтээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43.6-д заасны дагуу суутган барьцаа хөрөнгийн дансанд байршуулах асуудлыг тухайн төсөл, арга хэмжээний гэрээний тусгай нөхцөлд тусгасан байх;" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-т "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Гэрээнд заасан чанарын баталгааны 16,950,000.00 (арван зургаан сая есөн зуун тавин мянган) төгрөгийг "Смарт прожект" ХХК-аар төлүүлж, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын төрийн сан банкин дахь Хөрөнгө оруулалтын барьцааны 100900009356 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын гүйцэтгэх захирал (Д.Эрдэнэбаяр), ахлах нягтлан бодогч (Ч.Аюурзана) нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБЯАР  
Ж.БҮЖИНХАНД

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, I-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264330

Z:\Akt\2026\0316 SAG-4.Docx

1526200118



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 562/АД160259

Улаанбаатар хот

САГ-2026/19/КА-СТА - ТӨҮГ

Зөрчлийг арилгах тухай



Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хэрэгжүүлж буй Орон нутгийн хөгжлийн төвд байгалийн нөхцөл нөөцөд тулгуурлан үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборын ТЭЗҮ /Хөвсгөл аймаг/ боловсруулахаар "Эс Ай Си Эй" ХХК-тай 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр 413,891,940.00 (дөрвөн зуун арван гурван сая найман зуун ерэн нэгэн мянга есөн зуун дөчин) төгрөгийн гэрээ байгуулж эхний үе шатны 30 хувийн санхүүжилт болох 124,167,582.00 (нэг зуун хорин дөрвөн сая нэг зуун жаран долоон мянга таван зуун наян хоёр) төгрөгийг 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр санхүүжүүлсэн боловч гэрээг дүгнээгүй, гэрээний хугацаа 2025 оны 12 дугаар сарын 30-ний өдрөөр дуусгавар болсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын гүйцэтгэх захирал, Хүнс, Хөдөө, Аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн дарга, "Эс Ай Си Эй" ХХК-ийн гүйцэтгэх захирал нарын хооронд 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан "Орон нутгийн хөгжлийн төвд хөдөө аж ахуйн нөөцөд тулгуурлан үйлдвэрлэл, үйлчилгээ, бирж, тээвэр логистикийн цогцолбор ТЭЗҮ" боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээний 1.2-т "Гэрээний хугацаа 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн хооронд байна", 8.2-т "Захиалагч дээрх үндэслэлээс гадна хэдий ч гэрээг цуцалж болно", 9.5-д "Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0.05 хувиар заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна", 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн гэрээний нэмэлт өөрчлөлтийн 2.1-т Гэрээний 1.2 дахь хэсэгт... гэснийг "Гэрээний хугацаа нь 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хооронд байна" гэж өөрчлөх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний хугацаа дууссан байхад хэрэгжилтийг бүрэн хангуулаагүй зөрчлийг арилгаж, гэрээг дүгнэн биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын гүйцэтгэх захирал (Д.Эрдэнэбаяр), ахлах нягтлан бодогч (Ч.Аюурзана) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ  
АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦОГБАЯР  
АХЛАХ АУДИТОР  Ж.БҮЖИНХАНД





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 563/АД160259

Улаанбаатар хот

САГ-2026/19/НА-СТА-ТӨҮГ

Зөрчлийг арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хэрэгжүүлж буй Мэдээллийн технологийн төрөлжсөн төвийг байгуулах ТЭЗҮ, зураг төсөл /6 бүс тус бүрд/ боловсруулахаар "Өрнөлпроект" ХХК-тай 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 746,540,295.00 (долоон зуун дөчин зургаан сая таван зуун дөчин мянга хоёр зуун ерэн таван) төгрөгийн гэрээ байгуулж эхний болон дундын үе шатны 70 хувийн санхүүжилт болох 512,126,642.86 (таван зуун арван хоёр сая нэг зуун хорин зургаан мянга зургаан зуун дөчин хоёр төгрөг наян зургаан мөнгө) төгрөгийг санхүүжүүлсэн боловч гэрээг дүгнээгүй, гэрээний хугацаа 2025 оны 12 дугаар сарын 30-ний өдрөөр дуусгавар болсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын гүйцэтгэх захирал, Цахим хөгжил, Инновац, Харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, "Өрнөлпроект" ХХК-ийн захирал нарын хооронд 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан "Мэдээллийн технологийн төрөлжсөн төвийг байгуулах ТЭЗҮ, зураг төсөл /6 бүс тус бүрд/" боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээний 1.2-т "Гэрээний хугацаа 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн хооронд байна", 8.2-т "Захиалагч дээрх үндэслэлээс гадна хэдий ч гэрээг цуцалж болно", 9.5-д "Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0.05 хувиар заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна", 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн гэрээний нэмэлт өөрчлөлтийн 2.1-т "Гэрээний 1.2 дахь хэсэгт... гэснийг "Гэрээний хугацаа нь 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хооронд байна" гэж өөрчлөх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний хугацаа дууссан байхад хэрэгжилтийг бүрэн хангуулаагүй зөрчлийг арилгаж, гэрээг дүгнэн биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын гүйцэтгэх захирал (Д.Эрдэнэбаяр), ахлах нягтлан бодогч (Ч.Аюурзана) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 564/A0160259

Улаанбаатар хот

САГ - 2026/19/КА - СТА - ТӨҮГ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим системд байршуулбал зохих зарим мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Тухайлбал:

- ✓ Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг- 6 удаа;
- ✓ Дараа жилийн зорилтот түвшин-1удаа;
- ✓ Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт-3 удаа;
- ✓ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 14 мэдээллийн 4,053,663,350.00 (дөрвөн тэрбум тавин гурван сая зургаан зуун жаран гурван мянга гурван зуун тавин) төгрөг;
- ✓ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн 30 гүйлгээний 1,272,081,506.56 (нэг тэрбум хоёр зуун далан хоёр сая наян нэгэн мянга таван зуун зургаан төгрөг тавин зургаан мөнгө) төгрөгийн мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.3-т "тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-284230


Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-6.Docx

алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны тухай хуульд заасан цаглаварт хугацаанд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, давтан гаргасан, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын гүйцэтгэх захирал (Д.Эрдэнэбаяр), ахлах нягтлан бодогч (Ч.Аюурзана) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Ж.БҮЖИНХАНД